



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/38.

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай


Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай зочид буудал, дэн буудлуудын удирдах ажилтан, менежерүүдэд зориулсан “Найрсаг Улаанбаатар аялал жуулчлалын мэргэжил сурталчлах өдөрлөг, сургалт” зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 300,000 /Гурван зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2014 оны 06 сарын 02-ний өдрийн 138 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



**"НАЙРСАГ УЛААНБААТАР" АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖИЛ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ, СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Зорилго: Нийслэл хотын зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээ чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох боломжийг олгоход энэхүү өдөрлөг, сургалтын зорилго оршино.

Сургалтын агуулга: Сургалтыг танхимын сургалт, үзүүлэх сургалт гэсэн хоёр хэлбэрээр зохион байгуулна. Үзүүлэх сургалтаар нийслэлийн шилдэг зочид буудлуудыг сонгон авч тухайн дүүргийн зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулж, зочид буудлын үйлчилгээний стандарт шаардлага, түүний хэрэгжилтийг бодитоор үзүүлж тайлбарлах, мэргэжлийн ажилтны ур чадварыг биечлэн үзүүлнэ. Танхимын сургалтаар зочид буудал, дэн буудлын үйлчилгээ эрхлэгчдэд харилцаа ёс зүйн хандлага, хууль эрх зүй, стандартын талаарх мэдээллийг өгнө.

Хамрах хүрээ: Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй энгийн зочид буудал, дэн буудлуудын удирдлага, менежерүүд болон үйлчилгээний ажилтнууд хамрагдана.

Зохион байгуулагчид: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын зочид буудлуудын холбоо, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтэс.

Хугацаа: 2014 оны 6-р сарын 10-наас 6-р сарын 12-ны өдөр хүртэл явагдана.

Хүрэх үр дүн: Нийслэлийн зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээ, стандартын шаардлага хангаж буй байдал, эрүүл ахуй, аюулгүй байдлын түвшинд ахиц гарна.

Сургалтын хуваарь:

№	Хамрагдах дүүрэг	Сургалт зохион байгуулах газар	Хугацаа
1	Баянгол дүүрэг	"Сүнжин гранд" зочид буудал	6-р сарын 10-ны өдрийн 09.00-14.00 цагт
2	Баянзүрх дүүрэг	"Сүнжин гранд" зочид буудал	6-р сарын 10-ны өдрийн 13.00-18.00 цагт
3	Сүхбаатар дүүрэг	"Чингис хаан" зочид буудал	6-р сарын 11-ний өдрийн 09.00-14.00 цагт
4	Чингэлтэй дүүрэг	"Чингис хаан" зочид буудал	6-р сарын 11-ний өдрийн 13.00-18.00 цагт
5	Хан-Уул дүүрэг	"UB city" зочид буудал	6-р сарын 12-ны өдрийн 09.00-14.00 цагт
6	Сонгинохайрхан	"UB city" зочид буудал	6-р сарын 12-ны өдрийн 13.00-18.00 цагт


Үзүүлэх сургалтын хөтөлбөр:

№	Сэдэв	Хариуцах ажилтан	Хугацаа
1	Өглөөний хоолны иж бүрдэл	Зочид буудлын тогооч	20 мин
2	Зочны өрөөний ор засалт	Өрөөний үйлчлэгч	6-10 мин
3	Нийтийн талбайн цэвэрлэгээ	Талбайн үйлчлэгч	20 мин
4	Зочныг бүртгэх, мэдээлэл өгөх	Зочин хүлээн авагч	20 мин
5	Зочны хувцас угаалга индүүдлэг	Угаалгын ажилтан	20 мин
6	Өдрийн хоолоор зочинд үйлчлэх, ширээ засах	Зөөгч	20 мин
Нийт хугацаа			110 мин

Танхимын сургалтын хөтөлбөр:

№	Сэдэв	Хариуцах ажилтан	Хугацаа /академик цаг 45 минут/
1	Зочид буудал, дэн буудлын стандарт талаарх ойлголт	Монголын зочид буудлуудын холбоо	1
2	Харилцааны ур чадвар эзэмших -Зан төлөвийн шинжүүдэд тохируулан харилцах -Өөрийгөө танин мэдэх -Цаг төлөвлөлт, хувцаслах соёл - Ажлын байранд бусадтай хамтран ажиллах -Хамт олны нөхөрсөг харилцааг бий болгох	Технологийн дээд сургууль	2
3	Хууль эрх зүйн талаарх ойлголт	Нийслэлийн Цагдаагийн газар	1
	Нийт цаг		180 минут

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2014 оны 06 сарын 02-ний өдрийн 48 тоот
тушаалын хөрдугаар хавсралт



"НАЙРСАГ УЛААНБААТАР" АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖИЛ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ,
СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/
1.	Багшийн зардал /Технологийн дээд сургууль/	6	50000	300,000
	НИЙТ			300,000

ТӨСӨВ ЗОХИОСОН:

НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш.УНДАРМАА

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА